

ТУШААЛЫН ТӨСӨЛ

2026 оны ... сарын өдөр

Журамд нэмэлт оруулах тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн 16.1.1, 16.1.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 1 дүгээр хавсралтын 11.1² дахь заалтын “Нийслэлийн үнэт цаас” гэсний дараа “, аймгийн үнэт цаас**” гэж, “ногоон орон сууц худалдан авах, эсвэл барих зорилго бүхий төгрөгөөр олгосон зээл байна.” гэсний дараа “**Нийслэл, аймгийн үнэт цаас нь сүүлийн гурван жилд Монгол Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлогын (арифметик) дундаж дүнгийн 50.0 хувиас хэтрэхгүй хэмжээтэй, тодорхой эргэн төлөлтийн хуваарьтай бөгөөд төлбөрийн үүргийн гүйцэтгэл нь аливаа төслийн үр дүнгээс хамаарахгүй, Улсын Их Хурлаас тогтоосон өрийн хязгаарын хүрээнд төсвийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй байх шаардлагыг хангасан байна. Тухайн үнэт цаас нь дээрх шаардлагыг бүрэн хангасан эсэхийг Монголбанк тогтоогоогүй тохиолдолд нийслэл, аймгийн үнэт цаасны эрсдэлийн жинг тодорхойлоход бусад үнэт цаастай ижил зохицуулалтыг баримтална.” гэж тус тус нэмсүгэй.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Банкны хяналт шалгалтын газарт үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

С.НАРАНЦОГТ